



Гаалийн ерөнхий газрын 2024 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 01/2629 албан бичгийн хавсралт

“ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ” НИЙ УХГО207
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
 /2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар/

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7

Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх

1.1	<p>Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг: а/ Байгууллагын албан ёсны цахим хуудас, б/ Сошиал сувгууд, в/ Дотоод сүлжээ, г/ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, д/ Мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/ Бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж,</p>	<p>-Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; -Түгээсэн, хүрсэн дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрд тайлагнадаг байх; -Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.</p>	<p>Жилдээ</p>	<p>Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг тогтмол байршуулж, олон нийтэд сурталчилсан байна.</p>	<p>ХЭРЭГЖИЛТ: Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төв /https://iaas.mn/ фэйсбүүк пэйж хуудсанд байршуулсан контентуудаас “Авлигын эсрэг нэгдье”, “Үгүй гэж хэлээд өөрчилье” гэсэн уриатай нийт 11 контентыг Гаалийн байгууллагын албан ёсны “Монголын гааль” https://customs.gov.mn/ фэйсбүүк пэйж хуудас болон харьяа 19 гаалийн газар, хороод /https://zamiinuud.customs.gov.mn/, https://selenge.customs.gov.mn/, chinggis Khaan.customs.gov.mn, https://gashuunsukhait.customs.gov.mn/, “Дорнод аймаг дахь гаалийн газар” фэйсбүүк хаяг, “Шивээхүрэн Дэх гаалийн газар” фэйсбүүк хаяг, https://post.customs.gov.mn/, https://orkhon.customs.gov.mn/, https://khovd.customs.gov.mn, “Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар” фэйсбүүк хаяг, https://uvs.customs.gov.mn, https://sainshand.customs.gov.mn, “Дархан-Уул аймаг дахь гаалийн газар” фэйсбүүк хаяг, “Сүхбаатар аймгийн Бичигт Дэх гаалийн газар” фэйсбүүк хаяг, https://gar.mof.gov.mn/ReportFormSettings/ReportOrganizationData, “Ханги дахь гаалийн газар” Facebook хаяг/-ын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажилласан. Гаалийн ерөнхий газраас Авлигатай тэмцэх газартай хамтран байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 3 минутын видео шторкыг хамтран хийж “Монголын гааль” фэйсбүүк пэйж хуудас болон харьяа 19 гаалийн газар, хороод https://ub.customs.gov.mn, ын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажилласан.</p>	<p align="right">90</p>
-----	--	--	---------------	--	--	--------------------------------

	олон нийтэд хүргэх				<p>Харьяа гаалийн газар, хороодоос Орхон аймаг дахь гаалийн газрын хамт олон "Авлигын эсрэг хамтдаа нэгдье" видео контент /42 секундын/-ыг хийж, https://ogkhon.customs.gov.mn/ пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажилласан.</p> <p>/Нотломжийг программд оруулсан/</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: АТГ-ын Олон нийтийн төв фэйсбүүк пэйж хуудсанд байршуулсан соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудаас 11, Гаалийн ерөнхий газар, АТГ-тай хамтран гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 1 шторк, Орхон аймаг дахь гаалийн газраас "Авлигын эсрэг хамтдаа нэгдье" видео контент зэрэг нийт 13 видео контентыг Гаалийн байгууллагын албан ёсны "Монголын гааль" фэйсбүүк пэйж хуудас болон харьяа 19 гаалийн газар, хороодын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан ажилласан.</p> <p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын үйл ажиллагааны онцлолт тохируулан Замын-Үүд дэх гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газар, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар, Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороонуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэн, аж ахуйн нэгжид сурталчлах, соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөгийг тухайн гаалийн газар, хороодын онцлолт тохируулан зохион байгуулан ажилласан. /Нотломжийг программд оруулсан/</p>	100
1.2	Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлолт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	-Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; -Үр дүнг тооцсон байх.	Жилдээ	Нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулсан байна.	<p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагын үйл ажиллагааны онцлолт тохируулан эхний хагас жилийн байдлаар 11 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгөөр Гаалийн тухай хууль, Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэн, аж ахуйн нэгжид сурталчлан соён гэгээрүүлэн ажилласан. Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан нь өмнөх оны хагас жилээс 2.7 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөөс авсан санал, хүсэлтийг үндэслэн 3, 4 дүгээр улиралд арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.</p> <p>ХЭРЭГЖИЛТ: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэн, аж ахуйн нэгжид сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Замын-Үүд дэх гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Улаанбаатар хот дахь</p>	100
1.3	Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан	-Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат	Жилдээ	Эрхлэн гаргадаг сэтгүүл, иргэдэд тараадаг		

	<p>эрхлэн гаргадаг ном, гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах</p>	<p>эх сурвалжаас авсан байх; -Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; -Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; -Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.</p>	<p>хэвлэмэл материалд авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилсан байна.</p>	<p>гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газар, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар, Завхан аймгийн Арцсуурь дахь гаалийн хороонуудад нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулан ажиллахдаа гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан, авлигын хор хөнөөлийг ойлгуулсан, авлигын эсрэг нэгдэхийг уриалсан агуулга бүхий брошур, гарын авлага, хэвлэмэл материалыг хийж, нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлд тараан ажилласан. Брошур, гарын авлага, хэвлэмэл материалын арын доод буланд авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилсан болно. /Гаалийн байгууллагын хэмжээнд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгт тараагдсан брошур, гарын авлага, хэвлэмэл материалын затварыг программд оруулсан./</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэн, аж ахуйн нэгжид сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гаалийн байгууллагын хэмжээнд 11 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулан ажиллахдаа гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан, авлигын хор хөнөөлийг ойлгуулсан, авлигын эсрэг нэгдэхийг уриалсан агуулга бүхий брошур, гарын авлага, хэвлэмэл материалыг иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлд тараан ажилласан. Брошур, гарын авлага, хэвлэмэл материалын арын доод буланд авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилсан болно.</p>
<p>1.4</p>	<p>Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй контент бүтээж,</p>	<p>-Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; -Авлигыг мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх; -Олон нийтэд түгээсэн байх.</p>	<p>2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байна.</p>	<p>ХЭРЭГЖИЛТ: Бүрдүүлэлтийн цахим төвийн үйл ажиллагааг сурталчлах, авлигын эрсдэлээс ангид байх, авлигыг мэдээлэх 110 дугаарыг сурталчилсан видео контент /3 минутын/-ыг АТГ-тай хамтран хийж, Гаалийн байгууллагын албан ёсны "Монголын гааль" https://customs.gov.mn/ фэйсбүүк пэйж хуудас болон харьяа 19 гаалийн газар, хороод https://zamiinud.customs.gov.mn/, https://selenge.customs.gov.mn/, https://gashuulsukhait.customs.gov.mn/, "Дорнод аймаг дахь гаалийн газар" фэйсбүүк хаяг, https://orkhon.customs.gov.mn/, https://post.customs.gov.mn/, "Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар" фэйсбүүк хаяг, https://uvs.customs.gov.mn/, https://sainshand.customs.gov.mn/, "Дархан-Уул аймаг дахь гаалийн газар" фэйсбүүк хаяг, "Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газар" фэйсбүүк хаяг.</p>

	олон нийтэд хүргэсэн байх				<p>https://garp.mof.gov.mn/ReportFormSettings/ReportOrganizationData. “Ханги дах гаалийн газар” Facebook хаяг/-ын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан. Уг видео контентыг сонголын бэрхшээлтэй иргэдэд хүргэх зорилгоор дохионы хэлмэрчээр орчуулуулан олон нийтэд хүргэсэн. Мөн харьяа гаалийн газар, хороодоос Орхон аймаг дахь гаалийн газрын хамт олон “Бид төрийн тусгай албан хаагчид, авлигын эсрэг хамтдаа нэгдье” сэдвийн хүрээнд контент хийж, “Орхон аймаг дахь гаалийн газар” цахим хуудаст байршуулж, олон нийтэд түгээсэн. Гаалийн байгууллагын албан хаагчдад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 1 видео контентыг сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөн ажиллаж байна.</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Бүрдүүлэлтийн цахим төвийн үйл ажиллагааг сурталчлах, авлигын эрсдэлээс ангид байх, авлигыг мэдээлэх 110 дугаарыг сурталчилсан видео контентыг АТГ-тай хамтран хийж, Гаалийн байгууллагын албан ёсны “Монголын гааль” фэйсбүүк пэйж хуудас болон харьяа 19 гаалийн газар, хороодын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажилласан.</p>	
	Зорилт 1-ийн хүрээний нэгдсэн дүгнэлт: Арга хэмжээ тус бүрийн үнэлгээг авч үзвэл Дундаж хувь 95.0 % буюу “ тодорхой үр дүнд хүрсэн” байна.					
Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх						
2.1	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	-Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-зэс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх; -Сонгосон чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх;	Жилдээ	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлсэн байна.	<p>ХЭРЭГЖИЛТ: “Гаалийн байгууллагын 2023 онд “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Гаалийн ерөнхий газар болон харьяа 18 гаалийн газар, хороодын “Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал”-д мониторинг хийлгэхээр 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Меркадо ХХК-тай RCD/GET/2023 дугаартай судалгааны ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу гаалийн байгууллагын “Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал”-д мониторинг хийж, 6 агуулгын хүрээнд нийт 90 хуудас тайланг ирүүлсэн. Тайланд ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу харьяа гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллах талаар Захиргааны удирдлагын газрын 2024 оны 97 дугаар дотоод зурвасыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэн ажилласан.</p> <p>“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд журамд заасан чиглэлүүдээс ямар төрлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар мониторинг хийлгэх</p>	90

		<p>-Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; -Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх.</p>			<p>шаардлагатай байгаа талаар санал авахаар Захиргааны удирдлагын газрын 2024 оны 85 дугаар дотоод зурвасаар зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас санал авч ажилласан. Ирүүлсэн саналыг нэгтгэн сүүлийн хагас жилд журмын хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөөд байна. /Нотломжийг программд оруулсан./</p>
<p>2.2</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх</p>	<p>-Салбар бүрд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; -Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; -Үр дүнг тооцож, тайлагнасан байх.</p>	<p>Жилдээ</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн байна.</p>	<p>ХҮРСЭН ТҮВШИН: "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд журамд заасан чиглэлүүдээс 2024 оны сүүлийн хагас жилд ямар төрлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар мониторинг хийлгэх шаардлагатай байгаа талаар санал авч, саналыг нэгтгэн ажиллаж байна.</p> <p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагаас эхний хагас жилд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд: "Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад малын гаралтай хүнсний бус бүтээгдэхүүн" /малын боловсруулсан яс, өөхөн тос, эвэр туурай, уураг гэх мэт/ экспортолдог аж ахуйн нэгжүүдэд эрсдэлийн хянан магадлагаа хийхтэй холбогдуулан тухайн бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгж, экспортлох хүсэлт гаргасан 10 аж ахуйн нэгж, байгууллагын 18 удирдах албан тушаалтанд "Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үйлдвэрийн зориулалтаар ашиглах мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн экспортлох үеийн мал эмнэлэг, ариун цэвэр шаардлагын тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын протокол"-ыг танилцуулж, шалгалтад хэрхэн бэлтгэх талаар сургалт зохион байгуулж, аж ахуйн нэгжид асуудлыг тодорхой болгон зөвлөмж өгч ажилласан. "Хүнсний баталгаат байдлын мэдээлэл, хариу арга хэмжээний нэгдсэн систем"-ийн хэрэглэгчдийн зөвлөлдөх уулзалтад 2024 оны 01 дүгээр сарын 30-31-ний өдрүүдэд хэлэлцүүлэгт оролцож, хүнс импортлогч 110 аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөмж, мэдээлэл өгсөн.</p> <p>Гаалийн зуучлагч байгууллагуудын Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт нийт 4 удаагийн 520 цагийн сургалтыг хийж, 248 бүртгэгдсэн мэргэжилтнийг хамруулсан. Үүнээс 12 цагийн сургалтыг авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулан ажилласан.</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагаас эхний хагас жилд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд</p>

					<p>иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Сүүлийн хагас жилд салбар бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>ХЭРЭГЖИЛТ: Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах ажлын хүрээнд Шилэн дансны цахим хуудас, Гаалийн байгууллагын цахим хуудсанд дээрх мэдээллийг хугацаанд нь байршуулан ажилласан. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр Гаалийн ерөнхий газарт 2024 онд санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн байдлаар нийт 15 тендерийг зарласан ба Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу Үнэлгээний хорооны гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус гишүүн байна гэж заасны дагуу төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан ажилласан. Төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг нээлттэй, ил тод байдлаар Шилэн дансны цахим хуудас, Гаалийн байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулан ажиллаж байна. АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжих "Хилийн үйлчилгээг сайжруулах бус нутгийн төсөл"-ийн хүрээнд Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо хилийн боомтод хийгдсэн өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын нээлттэй арга хэмжээ 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, УИХ-ын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, ОХУ-ын Тува улсын Засгийн газрын тэргүүн Хавалик.В нарын хүндэт зочид, төлөөлөгчид зэрэг албаны хүмүүс хүрэлцэн ирсэн болон боомтын бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэсэн. https://uvs.customs.gov.mn/?p=6149c /Нотломжийг програмд оруулсан./</p>
<p>2.3</p>	<p>Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, олон нийтийн байгууллагын оролцоо хангах</p>	<p>-2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын арга төсөл, арга хэмжээний хэрэгжилт, /гүйцэтгэл/-ийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх; -Төсвийн хөрөнгө оруулалтын арга төсөл, арга хэмжээний хэрэгжилт, /гүйцэтгэл/-тэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах; -Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх.</p>	<p>Жилдээ</p>	<p>Төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангасан байна.</p>	<p>100</p>

					<p>арга хэмжээ 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд арга хэмжээг иргэд, олон нийтэд хүргэсэн.</p> <p>ХЭРЭГЖИЛТ: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн хүрээнд Гаалийн лавлах 1800-1281 утас, Засгийн газрын 11-11 төв, Цахим бүрдүүлэлтийн төв, харьяа гаалийн газар, хороодор дамжуулан гаалийн байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын ёс зүй, гаалийн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, холбогдох зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодод шилжүүлж, шуурхай шийдвэрлүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Гаалийн лавлах 1800-1281 утсанд: 59 гомдол, 5 зөрчлийн мэдээлэл, 7 санал, 8 хүсэлт, 1 шүүмжлэл, асуулт лавлагаа 2692 нийт 2772 дуудлага мэдээлэл хүлээн авсан байна. 2. Цахим бүрдүүлэлтийн төвийн 70001280 утсанд: 257 гомдол, 4 санал, 405 хүсэлт, 1 шүүмжлэл, асуулт лавлагаа 194 нийт 861 дуудлага мэдээлэл хүлээн авсан байна. 3. Харьяа гаалийн газар, хороодын жижүүрийн утсанд: 26 гомдол, 9 хүсэлт, 7 санал, 11 зөрчлийн мэдээлэл, асуулт лавлагаа 5 нийт 58 дуудлага мэдээлэл хүлээн авсан байна. 4. Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд: 104 гомдол, 7 санал, 4 хүсэлт, талархал 2 нийт 117 дуудлага мэдээлэл тус тус хүлээн авч хуулийн хүрээнд түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. <p>Гаалийн байгууллагаас сүүлийн хагас жилд харьяа гаалийн газар, хороодод ашиглаж буй гомдол, мэдээлэл хүлээн авч байгаа жижүүрийн утасны дуудлагыг Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарт холбон, дуудлага шилжүүлэх үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Албан хаагчдын хүнд сурталтай холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үр дүнд Бүрдүүлэлтийн цахим төв, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Улаанбаатар хот дахь гаалийн газруудын албан хаагчдад авлига, ашиг сонирхлоос ангид байх чиглэлээр сургалт зохион байгуулан ажилласан.</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Эхний хагас жилд гаалийн байгууллагад ирүүлсэн гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 84%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс гомдлын төрлөөр нь</p>
2.4	<p>Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших</p>	<p>-Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; -Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; -Иргэд, олон нийтээс "Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэлд холбоотой гомдол мэдээлэл"-д дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.</p>	Жилдээ	<p>Ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.</p>	

						өмнөх оны мөн үетэй харьцуулахад барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээ, бичиг баримттай холбоотой гомдлын тоо 3 дахин нэмэгдсэн байгаа нь нийт гомдлын тоо есөхөд нөлөөлсөн байна.	
	Зорилт 2-ын хүрээний нэгдсэн дүгнэлт: Арга хэмжээ тус бүрийн үнэлгээг авч үзвэл Дундаж хувь 95.0% буюу "тодорхой үр дүнд хүрсэн" байна.						
Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах							
3.1	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, зүтгэмжийг талаар иргэд, олон нийтэд судалгаа, санал асуулга авах; -Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; -Хэрэгжилтийг тайлагнах.	Жилдээ		Цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний чанар, зүтгэмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулсан байна.		ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, зүтгэмжийг дээшлүүлэх чиглэлээр www.gaali.mn системийг нэвтрүүлэн аж ахуйн нэгжид 12 төрлийн ахуйн нэгжид 33 төрлийн үйлчилгээ, иргэдэд үзүүлэх 12 төрлийн үйлчилгээг цахимаар авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Гаалийн байгууллагаас цахимаар иргэн, аж ахуйн нэгжид үзүүлж байгаа үйлчилгээний чанар зүтгэмжийн талаар иргэд, олон нийтээс санал асуулга авах ажлыг сүүлийн хугацаа жилд хийхээр төлөвлөн ажиллаж байна. /Гаалийн байгууллагаас цахимаар аж ахуйн нэгжид 33 төрлийн үйлчилгээ, иргэдэд үзүүлэх 12 төрлийн үйлчилгээний талаарх мэдээллийг хавсралт хэсэгт файл оруулав./	90
3.2	Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	Жилдээ		Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.		ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагаас www.gaali.mn системийг нэвтрүүлэн аж ахуйн нэгжид 33 төрлийн үйлчилгээ, иргэдэд 12 төрлийн үйлчилгээг цахимаар авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн.	100
						ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулах чиглэлээр Сангийн сайдын 2024 оны 6 дугаар тушаалаар Дотоод хяналт, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгжийг байгуулсан. Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/123 дугаар тушаалаар Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийг 7 хүний ГТ-71 бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Уг нэгж нь гаалийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэл тооцох, дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх, байгууллага, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах, гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, хянан шийдвэрлэх үндсэн чиг үүрэгтэй нэгж юм.	
						ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой байж болзошгүй асуудлыг шалгуулахаар Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн 01-5/1279 албан бичгээр Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн ажилласан. Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсээс Бүрдүүлэлтийн цахим төв, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Дархан-Уул аймаг дахь	

		<p>арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлолт тохируулан хэрэгжүүлсэн байх.</p>		<p>гаалийн газар, Улс хоорондын шуудан илтээмжийн гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Улаанбаатар хот дахь гаалийн газруудын албан хаагчдад Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн чиг үүргийг танилцуулан 2024 оны эхний 5 сарын байдлаар гаалийн байгууллагын албан хаагчдтай холбоотойгоор Засгийн газрын 11-11, Гаалийн лавлах 1800-1281 утсанд ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаар танилцуулга хийж ажилласан. Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байх чиглэлээр харьяа гаалийн газар, хороодоос Замын-Үүд дэх гаалийн газар, Дорнод аймаг дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт 01-2/447, 01-2/448, 01-2/449 албан бичгүүдээр чиглэл хүргүүлэн ажилласан. /Холбогдох нотломжийг программд оруулсан/</p>	
<p>3.3</p>	<p>Тухайн байгууллага өөрийн ажиллагааны онцлолт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>-Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулаараа давхцахгүй байх; -Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээ, хэрэгжүүлж буй арга хэмжээ онцлолт тохирсон байх.</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулах чиглэлээр Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/123 дугаар тушаалаар Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийг 7 хүний ЛТ-7/ бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Эхний хагас жилийн байдлаар авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой байж болзошгүй асуудлыг шалгуулахаар 01-5/1279 албан бичгээр Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн ажилласан нь гаалийн байгууллагын дотоод хяналтын механизм сайжирч байгаагийн илрэл юм.</p> <p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагаас эхний хагас жилийн байдлаар авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр дараах ажлыг шинээр санаачлан хэрэгжүүлж ажилласан. Үүнд: 2024 оны эхнээс гаалийн байгууллагад шинээр болон шилжин томилогдож буй албан хаагчдаас авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдох, өртөхөөс урьдчилан сэргийлэх хүрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албаны тухай болон Гаалийн тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй, ашиг сонирхлын зөрчилгүй, өргөсөн тангарагтаа ҮНЭНЧ байж, Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтын талаарх зохицуулалттай дахин танилцаад мөрдөж ажиллахаа илэрхийлсэн баталгаа гаруулан авч, үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. ДТБ-ын Эрсдэлийн удирдлагын компендиумд үзүүлсэн үйл ажиллагааны зураглалын дагуу эрсдэлийн дүн шинжилгээ хийж, таньж тодорхойлсон гурван хүчин зүйл тус бүрээр гарч болзошгүй</p>	<p>95</p>

3.3.1	<p>Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан дүрэм, журмыг Сангийн сайд, Засгийн газрын толгоол шийдвэрээр хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр болгох чиглэлээр хуульд нийцүүлэн дахин</p>	<p>-Хүчин төгөлдөр бус болгосон дүрэм, журамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байх; -Хуульд нийцүүлэн дахин боловсруулж, батлуулж мөрдүүлсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	Жилдээ	<p>Мөрдөгдөж байсан дүрэм, журмыг хүчин төгөлдөр бус болгосон тохиолдолд тэдгээрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хуульд нийцүүлэн дахин боловсруулан батлуулж, мөрдүүлсэн байна.</p>	<p>эрсдэлийг тооцож, тухайн эрсдэл гарах магадлал, түүний үр дагаврын оноог "3х3 Матриц"-ын тусламжтай үнэлж, эрсдэлийн тэргүүлэх чиглэлийг гаргасан. Гурван хүчин зүйлээс Тэргүүлэх чиглэлийн эрсдэл нь "Мэдээллийн технологи", дараа нь "Бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг" орсон. "Хүний нөөц" өндөр эрсдэлтэй гарсан боловч, нөгөө хоёр хүчин зүйлтэй харьцуулахад бага эрсдэлтэй гэж тооцоологдсон. Эрсдэлийн тооцооны үр дүнгээр гурван хүчин зүйлийг ач холбогдлоор нь эрэмбэлэн, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг тэргүүлэх чиглэлийн, өндөр болон дунд эрсдэл тус бүрээр гаргасан. Эдгээр гурван хүчин зүйлийн хүрээнд 24 арга хэмжээг төлөвлөн, төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд эрсдэлийг бууруулах зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаад байна. /Холбогдох нотломжийг программд оруулсан/</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагад шинээр болон шилжин томилогдож буй албан хаагчдаас ҮНЭНЧ байж, Албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтын талаарх баталгаа гаргуулан авч ажилласан. ДГБ-ын Эрсдэлийн удирдлагын компендиумд үзүүлсэн үйл ажиллагааны зураглалын дагуу эрсдэлийн дүн шинжилгээ хийж эрсдэлийг бууруулах зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаад байна.</p>	
				<p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар Гаалийн ерөнхий газрын даргын баталсан нийтээр болон дотооддоо дагаж мөрдөх хэм хэмжээний актаас хүчин төгөлдөр бус болгосон хэм хэмжээний акт байхгүй болно. АТТ-ын 2024 оны 01/4936 албан бичгээр Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан "Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах талаар зөвлөмж ирүүлсний дагуу журмын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулан гаалийн байгууллагын https://customs.gov.mn цахим хуудсанд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд байршуулан санал авч, саналыг нэгтгэн явцыг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/2147 албан бичгээр АТТ-т хүргүүлж, танилцуулсан. Үүний дараа 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн ээлжит 4 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, 100 хувийн дэмжлэг авч, хурлын 06/05 шийдвэр гарсан бөгөөд батлуулахад бэлэн болоод байна. /Нотломжийг программд оруулсан/</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар Гаалийн ерөнхий газрын даргын баталсан нийтээр болон дотооддоо дагаж мөрдөх хэм хэмжээний актаас</p>	90	

3.3.2	<p>боловсруулах, батлуулж мөрдүүлэх</p> <p>Гаалийн байгууллагаас цахимаар үзүүлж байгаагаас бусад төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлсэн байх;</p>	<p>-Цахимаар үзүүлж байгаагаас бусад төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлсэн байх;</p> <p>-Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	Жилдээ	Цахимаар үзүүлж байгаагаас бусад төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүнд суртал, чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлсэн байна.	<p>хүчин төгөлдөр бус болгосон хэм хэмжээний акт байхгүй. Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан "Бараанаас сорьц, дээж, загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулан Мэргэжлийн зөвлөлийн ээлжит 4-р хуралдаанаар хэлэлцүүлж, 100 хувийн саналаар дэмжигдсэн.</p> <p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагаас цахимаар үзүүлж байгаагаас бусад төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа судалгааг авахаар Захиргааны удирдлагын газрын 2024 оны 31 дүгээр дотоод зурвасыг хүргүүлэн судалгааг нэгтгэн ажилласан. Гаалийн байгууллагаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад цахимаар үзүүлж байгаагаас бусад төрийн үйлчилгээнд Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт, ГИТ, ТИР тээвэрлэлт, тээврийн хэрэгсэл, Ачааны манифест нөхөн бичих, хяналт тавих үйл ажиллагаа, Гаалийн бүрдүүлэлтийн горим, тэдгээрт тавигдах шаардлага, бүрдүүлэлт бичиг баримт, Тарифын болон тарифын бус хязгаарлалттай барааны хяналт, квот бүртгэх, Оюуны өмчийн эрхэд хамаарах барааны хяналт, бүрдүүлэлт, Чөлөөт бүс,ТБД, ГББ-ийн горим, хяналт, ГХБ, ТБД, ГБА-д тавигдах шаардлага, Биет болон биет бус бараанд нөхөн бүрдүүлэлт хийх, архивын лавлагаа зэрэг үйлчилгээнүүдийг хүнд суртал, чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлж байна. Эдгээр үйлчилгээг цахимаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх боломж бололцоог судлан ажиллаж байна. /Нотломжийг программд оруулсан/</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагаас цахимаар үзүүлж байгаагаас бусад 10 гаруй төрлийн төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүнд суртал, чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлж байна. Эдгээр үйлчилгээг цахимаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх боломж, ажиллагааг судлан ажиллаж байна.</p>	100
3.3.3	<p>Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах</p>	<p>-Тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянасан, хэрэгжилтийг хангасан байх;</p> <p>-Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	Жилдээ	<p>Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангасан байна.</p>	<p>ХЭРЭГЖИЛТ: Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, хэрэгжилтийг хангах зорилгоор дараах 2 чиглэлээр ажилласан. Үүнд:</p> <p>1.Гаалийн ерөнхий газрын даргын 770 тушаал батлагдан гарсан бөгөөд Хуулийн хэлтсээс дээрх тушаалуудыг тухай бүр хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажилласан. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - А тушаал 343, - Б тушаал 427 байна. <p>2.Харьяа гаалийн газар, хороодын дарга нарын 2023 оны 12 дугаар сар, 2024 оны 01-05 дугаар сард баталсан нийт 620 тушаалыг хянаж, дараах "Захиргааны акт хянаж, зөвлөмж, чиглэл</p>	100

3.3.4	Гаалийн байгууллагын төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр ажиллах	-Төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр ажилласан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Жилдээ	Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр ажилласан байна.	<p>хүргүүлэх тухай" албан бичгээр зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1.Замын-Үүд дэх ГТ 2024.06.13-ны өдрийн №01-1.2/2413, 2.Сэлэнгэ аймаг дахь ГТ 2024.03.06-ны өдрийн №01-1.2/881, 2024.06.13-ны өдрийн №01-1.2/2414, 3.УХШИГТ-2024.03.06-ны өдрийн 01-1.2/874, 4.Гашуунсухайт дахь ГТ 2024.03.06-ны өдрийн №01-1.2/877, 2024.06.13-ны өдрийн №01-1.2/2415, 5.Дорнод аймаг дахь ГТ 2024.06.13-ны өдрийн №01-1.2/2416, 6.Шивээхүрэн дэх ГТ 2024.03.06-ны өдрийн №01-1.2/875, 2024.06.13-ны өдрийн №01-1.2/2421, 7.Орхон аймаг дахь ГТ 2024.03.06-ны өдрийн №01-1.2/878, 2024.06.13-ны өдрийн №01-1.2/2417, 8.Сайншанд дахь ГТ 2024.03.06-ны өдрийн №01-1.2/876 2024.06.13-ны өдрийн №01-1.2/2419, 9.Дархан-Уул аймаг дахь ГТ 2024.06.13-ны өдрийн №01-1.2/2420, 10.Баян-Өлгий аймаг дахь ГТ-2024.06.13-ны өдрийн №01-1.2/2418. 11. Говь-Алтай аймгийн Бургастай дахь ГХ 2024.03.06-ны өдрийн №01-1.2/880 <p>Эхний хагас жилийн байдлаар ГЕГ-ын даргын 770 тушаал батлагдан гарсан бөгөөд Хуулийн хэлтсээс дээрх тушаалуудыг тухай бүр хянаж, мөргөжил арга зүйн зөвлөгөө өгч, ажилласан. Харьяа гаалийн газар, хороодын дарга нар эхний хагас жилийн байдлаар нийт 620 тушаал гаргаж, тухай бүр Хуулийн хэлтэст хянуулан ажилласан. Хянуулан тушаалын дагуу "Захиргааны акт хянаж, зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай" албан бичгээр нийт 16 зөвлөмжийг харьяа гаалийн газар, хороодод хүргүүлэн ажилласан. /Нотломжийг программд оруулсан/</p> <p>ХЭРЭГЖИЛТ: Гаалийн байгууллагын төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороодын санхүүгийн албан хаагчдыг хамруулсан сургалтыг 2024 оны 1 дүгээр сард зохион байгуулсан. Тус сургалтад Сангийн яам, Төрийн сангийн газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Сангийн яамны төсөл ("Төрийн албаны цалингийн нэгдсэн систем") зэрэг газруудаас холбогдох мэргэжилтэн, зөвлөх албан хаагчид хүрэлцэн ирж, "Төсвийн төлөвлөлт, анхаарах асуудал", "Төрийн сангийн үйл ажиллагааны журам", "Төрийн худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, анхаарах асуудал", "Төрийн албаны цалингийн нэгдсэн системд тэтгэвэр, тэтгэмжийн тооцоолол хийх" зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулан ажилласан. Гаалийн байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар</p>
					90

					<p>Үндэсний аудитын газраас ирүүлсэн "Албан шаардлага"-ын хүрээнд Санхүү, хөрөнгө оруулалтын газар, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хамтран Үндэсний аудитын газраас гаалийн байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>ХҮРСЭН ТҮВШИН: Гаалийн байгууллагын төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр ГЕГ болон харьяа гаалийн газар, хороодын санхүүгийн албан хаагчдыг хамруулсан сургалтыг 2024 оны 1 дүгээр сард зохион байгуулсан. Үндэсний аудитын газраас гаалийн байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. /Нотломжийг программд оруулсан/</p>
	<p>Зорилт 3-ын хүрээний нэгдсэн дүгнэлт: Арга хэмжээ тус бүрийн үнэлгээг авч үзвэл Дундаж хувь 95.0 % буюу " тодорхой үр дүнд хүрсэн" байна.</p>				
	<p>Дүгнэлт: Арга хэмжээ тус бүрийн үнэлгээг авч үзвэл Дундаж хувь 95.0 % буюу " тодорхой үр дүнд хүрсэн" байна.</p>				

ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

2023 оны эхний хагас жилд тус бүрийн үнэлгээг авч үзвэл Дундаж хувь 90.0 % буюу " тодорхой үр дүнд хүрсэн" байсан бол 2024 оны эхний хагас жилд тус бүрийн үнэлгээг авч үзвэл Дундаж хувь 95.0 % буюу "тодорхой үр дүнд хүрсэн" байгаа нь 5%-иар өссөн үзүүлэлттэй байна.

"Нотломжийг программд оруулсан" гэж тайлагнасан нь <http://khutuibulvg.iaas.mn/iaas/riap/> цахим системээр гаалийн байгууллагын нэвтрэх эрхээр нэвтэрч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг илгээдэг байна.

"Гаалийн байгууллагын 2024 оны эхний хагас жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, 95 хувиар үнэлэв.